

LOCTITE

1001 Trout Brook Crossing
Rocky Hill, CT 06067-3910
Telephone: (860) 571-5100
FAX: (860) 571-5465

Product Description Sheet

Extend® Rust Treatment

Maintenance, Repair & Operations, March 2006

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЙЛБАР

Loctite® Extend® Rust Treatment бол хурдан хатдаг сүүн цагаан өнгөтэй латекс давхрага үүсгэдэг бөгөөд эзэвсэн метал гадаргуугийн зэврэлтийг хамгаалах зогсоох суурь үе тавихад зориулсан бүтээгдэхүүн болно.

НИЙТЛЭГ ХЭРЭГЛЭЭ

- Цэвэрлэх байгууламжийн яндан хоолой, хаалт, бэхэлгээ, нөөцлүүр сав, цахилгаан станц, орон сууцны болон нийтийн халаалт/хөргөлтийн системд
- Ачааны машин, чиргүүл, нөөцлөх сав
- Хашаа, хамгаалалтын хөдлөвч, түүзан дамжуулга, тулгуур багана
- Өргөгч кран, краны сум, төмөр торон шал, агааржуулах хоолой
- Гадаа байрлуулах сурталчилгааны самбарын хөл, жааз, хот, орон нутгийн авто, хурдны замын тэмдгийн хөл, жааз
- Тулгуур хана (Bulkheads), дээд давхар (overheads), тавцан (decks), тагны хаалт (hatch covers), усан онгоцны дарвуулын хөндлөвч (stacks) бүрхүүл (topcoat)
- Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, хадуур, анжис (plows), цан (discs), трактор, үрлэгч, хураагч (corn pickers)
- Хурдны зам засварын газрын цас арилгадаг тоног төхөөрөмж,
- Цаасны үйлдвэрийн тээрэм, химийн бодисын үйлдвэр, төмрийн үйлдвэр, яндан хоолой засвар, нөөцлүүр сав, тулгуур төмөр, хаалтууд
- Ган цутгах ба хэвлэх

БЭХЖЭЭГҮЙ МАТЕРИАЛЫН НИЙТЛЭГ ШИНЖ ЧАНАР

Химийн бодисын төрөл	Синтетик латекс резин
Харагдах байдал	Сүүн өнгөтэй шингэн
Үнэр	зөөлөн
Хувийн гравитац	1.20
Наалдамхай чанар	Flow similar to SAE 40 шиг урсамтгай, Моторын тос шиг - Motor Oil
Асах температур - Flash Point, TCC	Асдаггүй шингэн

ХАЛАЛТААС ХОВХОРОХ ЧАНАР

200°C хүртэл тэсвэрлэнэ. Богино хугацаанд 250°F хэмийг тэсвэрлэнэ.

ОРЧИН ТОЙРНЫ НӨХЦӨЛД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ

Loctite® Extend® Rust Treatment бүтээгдэхүүний хоёр давхар үе зөөлөн уур амьсгалтай газар ил байх чадвартай. 7-14 хоног хатааж бэхжүүлэх хэрэгтэй. Эрс тэс уур амьсгалтай орчинд хучиж хамгаалах хэрэгтэй.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Гадаргууг цэвэрлэж бэлдэх

1. Хуучирсан ган:

Сул зэв, овойсон зэвийг цэвэрлэх хэрэгтэй. Хатуурч барьцалдаж хувирсан зэв хамгаалах гадаргууд нөлөөлнө. Loctite® Extend® Rust Treatment бүтээгдэхүүнээр зэвийг идүүлж сайн үйлчлүүлэхийн тулд уг гадаргуу дээрх тос, тосолгооны материал, хуучин будаг, ган хайлах явцад үүссэн төмрийн исэл (mill scale), цутгах хэвний тос (form oil), хурууны хээ (fingerprints), усанд уусдаг гадаргуу (water soluble surfaces) хлоридыг цэвэрлэх хэрэгтэй. Сул зэв, ган хайлах явцад үүссэн төмрийн исэл (mill scale) болон тосон будгийг ган утсан щетоктой машинаар үрж цэвэрлээд тоос үртсийг нь усаар угааж цэвэрлэнэ. Гараар щетокдох, хусах, зүлгэх маягаар цэвэрлэж болно.

Тос, тосолгооны бохир, цутгах хэвний тос (form oil), хурууны хээ (fingerprints) зэргийг сул зэв арилгахаас өмнө цэвэрлэнэ. Цэвэр гадаргууд бага зэргийн зэвтэй буюу метал гадаргуу гарсан байх ёстой

2. Зэв үүсэх хугацаа ба харагдах байдал

Loctite® Extend® Rust Treatment-ийн үеийг хоёр давхарлаж тавих хэрэгтэй. Бага зэрэг зэвэрсэн ган (ган щеткоор цэвэрлэсэн) дээр эхний үеийг түрхэхэд 60 секундйн дотор ягаан туяатай болно. Удалгүй гялгар өнгөтэй болж өөрчлөгдөх ба гялгар хар өнгөтэй болохоор нь дараагийн үеийг тавих хэрэгтэй.

Хүчтэй зэвэрсэн ган (ган щеткоор цэвэрлэсэн) дээр эхний үеийг түрхэхэд хардуу ягаан өнгөтэй болно. Дараагийн үеийг энэ хар өнгө гялгар болж хувирахад тавих хэрэгтэй.

Хэрэглэх арга:

1. Холимогийг хэрэглэхээсээ өмнө урьчилан холь
2. Гадаргуу дээрх тос, хог, тосолгооны бохирдлыг цэвэрлэ. Сул болон хувирсан зэвийг ган утсан щеткоор үрж зайлуул. Зарим зэв гадаргуу дээр үлдэж болно.
3. Хольцоо түрхэхдээ цэвэр саванд хийж байгаад багсдаж үрж арчиж болно.
4. Бээлий өмс
5. Щетокдож, мөн дусааж хэрэглэж болно.
6. Үүний дараа 5 минутын дотор хар өнгийн бүрхэвчтэй болно. Өнгө нь жигд биш байвал хольцоо нэмж түрхэх хэрэгтэй. Дахин түрхэх хугацаа 15-30 минут байна. Будаг дуусгахаасаа өмнө 24 цаг хатаах хэрэгтэй.
7. Энэ будаг хийхдээ суурь үе нэмж тавих хэрэггүй. Тэхдээ цайвар өнгөтэй латкс болон металтай будгаар будах бол Loctite® Extend® Rust Treatment –ийн үе дээрээ уусгагчаа суурь үе тавих хэрэгтэй.
8. Хэрэглэсэн багс, өнхрүүл болон бусад багажаа угаалгын нунтагтай усаар даруй угааж цэвэрлэ. Шүршдэг төхөөрөмжөө мөн угаалгын нунтагтай усаар даруй угааж цэвэрлэ. Багажаа цэвэрлэлгүй хатаачихвал энэ Loctite® Extend® Rust Treatment бодис арилахгүй болно.

Хэрэглэхэд үедээ санаж байх зүйлс

1. Гадаргууг цэвэрлэж бэлдэхдээ сул, овойсон зэв, тос, тосолгооны материал, хуучин будаг, усанд уусдаг сульфат, хлорид, зүсэж хэрчихэд хэрэглэсэн тосны үлдэгдлийг сайн цэвэрлэх хэрэгтэй.
2. Элсэн цэвэрлэгээ хийхдээ хангалттай их материал ашиглах хэрэгтэй.
3. Бат бэхийг нь дээд зэрэгт хүргэхийн тулд хоёр давхар үе 4 микрон зузаан үе тавина.
4. Бүрээсийг бүрэн хатаж бэхжихээс өмнө усанд хийвэл цагаан өнгөтэй болж болно. Бүрэн хатаасны дараа хар өнгөтэй болно.

Хэрэглэх нөхцөл

Loctite® Extend® Rust Treatment-ийг гадаргууд түрхэхдээ агаарын хэм 50°F-ээс 90°F –ийн хооронд байх хугацаанд хэрэглэх ба нам температурт үйлчлэх чадвар нь удаан байна. Хэрэв температур хэт их байвал тавьсан үе давхрага нь хатах цэврүүтэж болно. Чийгшил их байвал удаан хатах боловч зэвийг идэх явцад сайн нөлөөлнө. Loctite® Extend® Rust Treatment-ийг манан будантай шүүдэр үүсэх нөхцөл, бороотой, шорвог ус үсэрч байгаа үед болон мөстэй үед ашиглаж болохгүй. Металын гадаргуу чийгтэй байж болох ч нойтон (усаар норсон) байх ёсгүй. **Loctite® Extend® Rust Treatment-ийг нарны гэрэлд байгаа гадаргууд хэрэглэж болохгүй.**

Багаж төхөөрөмж ашиглах

Loctite® Extend® Rust Treatment-ийг багс, өнхрүүлээр юмуу шүршиж болно. Багс ба өнхрүүлийг бага талбайд ашиглахад тохиромжтой. Урсах овойхоос сэргийлэхийн тулд эг удаад 1 хавтгай дөрвөлжин ярд талбайгаас илүүгүй талбайд түрх. Түрхэхдээ урагш хойш маягаар түрх. **Хэрэглээнээс үлдсэн материалаа анх авсан савандаа буцааж хийх буюу багсаа дүрж болохгүй. Loctite® Extend® Rust Treatment-ийг уусгагч бодисоор шингэлж огт болохгүй.**

Ихээхэн хэмжээний талбайд шүрших төхөөрөмж ашиглах хэрэгтэй. Агаргүй шүрших төхөөрөмж ашиглах нь хурдан бөгөөд гадаргад сайн нэвтрэх боломж олгох учир үр дүнтэй. Уламжлалт хийгээр шүрших төхөөрөмж хэрэглэж болох боловч Loctite® Extend® Rust Treatment –ийг сайн шүршихийн тулд усаар 10% хүртэл шингэлэх хэрэг гарч болно.

Чийг, уусгагч болон химийн бодист тэсвэртэй байдал

Loctite® Extend® Rust Treatment –ийг ус буюу шингэн дотор байнга ажиллах төхөөрөмжид хэрэглэж болохгүй. Үүнийг тухайн орчинд нь тэсвэртэй давхаргаар бүрэх ёстой. Латекс бүрээсийг зохих хамгаалалтын бүрээсгүйгээр хэрэглэж болохгүй.

Ийм бүрээсийг сонгохдоо байх орчин нөхцөлийг нь харгалзах ёстой. Тэдний шинж чанарыг хэрэглэгдэх нөхцөлөөр нь доор жагсаав. Үүнд:

- Чийг/шорвог устай орчин – Сайн хатуурдаг епоксид, нүүрсний давирхайтай епоксид, катализад оруулсан уретан, винил, хлоржуулсан резин
- Уусгагчид тэсвэртэй орчин - катализад оруулсан уретан, Сайн хатуурдаг епоксид, нүүрсний давирхайтай епоксид, винил
- Хүчилд эсвэртэй орчин - катализад оруулсан уретан, Сайн хатуурдаг епоксид, нүүрсний давирхайтай епоксид, винил
- Шүлтэнд тэсвэртэй орчин - катализад оруулсан уретан, Сайн хатуурдаг епоксид, нүүрсний давирхайтай епоксид, хлоржуулсан резин
- Исэлдүүлдэг бодист тэсвэртэй – винил, катализад оруулсан уретан,

- Элэгдэлд тэсвэртэй орчин – епоксид, уретан, алкидын давирхай

Гадаргуу дээр өрх, хонхор нүх үүсэх, хотойлт үүссэн байвал Loctite® Extend® Rust Treatment-ээр өтгөн суурь үеэ тавьж байгаад дээр нь хоёр давхар үе түрхэх юмуу зэврэлт үүсэхээс хангалттай хамгаалах давхрага хийж өгнө. **Бүх төрлийн будагтай газарт туршилтын нөхөөс тавих хэрэгтэй.** Энэ тал дээр найдвартай будаг юмуу хамгаалах давхрага нийлүүлдэг компани туслах боломжтой. Доор дурьдсан суурь үеийг Loctite® Extend® Rust Treatment- дээр түрхэж болохгүй. Үүнд:

- Цайрын тоос (цайр ихтэй суурь үе)
- Зэсийн нутаг (бохируулдаггүй будаг)
- Хромит агуулан үйлдвэрийн суурь үе тавих бодисуудыг ихэнх тохиолдолд хэрэглэж болох боловч тохирох эсэхийг нь турших хэрэгтэй.

Цэвэрлэх

Loctite® Extend® Rust Treatment бүтээгдэхүүн хатахаараа арилдаггүй учир үсэрсэн дуссан хэсгийг даруй арилгах хэрэгтэй. Энэ бодист дүрсэн багс, өнхрүүл тоног төхөөрөмжийг тэр дор нь савандаж крантны усаар угаах хэрэгтэй. Шүршдэг төхөөрөмжүүдээ мөн тэр дор нь савантай усаар угаагаад цэвэр усаар зайлж цэвэрлэнэ. Энэ аолимогийн саванд хатсан хальсан бүрхэвч үүсэхээс өмнө таглах хэрэгтэй.

PDS Extend Rust Treatment, March 2006

Loctite® Extend® Rust Treatment бодистой харьцах

Loctite® Extend® Rust Treatment бүтээгдэхүүн хувцсан дээр асгарсан бол түр хувцсаа тэр даруй крантны хүйтэн усаар норгож угаавал амархан арилна. Ийм цэвэрлэгээнд аммони, хүчтэй шүлт бүхий бодис болон халуун ус **хэрэглэж болохгүй.**

Гар, хумсаа савантай усанд сойзлож угаах хэрэгтэй. Гар дээрээ үүссэн Loctite® Extend® Rust Treatment-ийн төмрийн хольцтой хар толбыг цагааруулагч бодисны 1 нэгж ба крантны усны 4 нэгж холимоогоор угаагаад дараа нь савантай усаар угааж арилгана. Loctite® Extend® Rust Treatment-ийн асгарсан цалгисан газрыг савандаж крантны усаар зайлахад арилна.

Зайлуулж хаях

Тоног төхөөрөмж болон хувцсан дээр хатаж үлдсэн Loctite® Extend® Rust Treatment-ийн бүтээгдэхүүнийг будаг арилгагч мэт хүчтэй уусгагч бодис хэрэглэн цэвэрлэж болно. Мөн механик үйлчилгээ болгон үрж нухах хэрэг гарч болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ бүтээгдэхүүнийг дан хүчилтөрөгч/хүчилтөрөгч ихтэй системд хэрэглэхэд зохимжгүй бөгөөд хлортой юмуу хүчтэй исэлдүүлэгч материалуудыг хааж тусгаарлах зорилгоор ашиглаж болохгүй. Эдгээр бүтээгдэхүүнийг ашиглахдаа баримтлах мэдээллийг Аюулгүй ажиллагааны дагалдах хуудаснаас үзнэ үү.

Гадаргуу дээр үлдсэн бодисыг хатаж бэхжихээс нь өмнө усаар угаах бол тэр угаах уусмалаа энэ наалдамхай материалд ашиглаж болох эсэхийг шалгах хэрэгтэй. Зарим тохиолдолд тэдгээр угаах уусмал нь наалдамхай бодисын цаашдын бэхжилт болон эдэлгээнд нөлөөлдөг байна. Loctite® Extend® Rust Treatment-ийг пластик (ялангуяа хагарч болзошгүй термопластик материал) гадаргууд түрхэхийг зөвшөөрдөггүй. Ийм материалд түрхэж болох эсэхийг урьдчилан тодорхойлох хэрэгтэй.

Бусад мэдээлэл

Зүйлийн дугаар	Савны хэмжээ
75430	1 qt. Bottle
75448	1 gal. Bottle
75455	5 gal. Pail

Хадгалалт

Эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрийн нь саванд 8-28°C хэмд хадгална. Хөлдөөж болохгүй. Ийм нөхцөлд нэг жил хадгалж болно.

САВНААС НЬ ГАРГАЖ АВСАН БҮТЭЭГДЭХҮҮН АШИГЛАЛТЫН ЯВЦАД БОХИРДСОН БАЙЖ БОЛОХ УЧИР НЭГЭНТ ГАРГАЖ АВСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЭРГҮҮЛЖ САВАНД НЬ ХИЙЖ БОЛОХГҮЙ. КОНТАЙНЕРИЙГ САЙН ТАГЛАХ ХЭРЭГТЭЙ.

Өгөгдлүүдийн утга

Энд орсон өгөгдлүүдийг дундаж нийтлэг хэмжээгээр нь өгсөн байгаа. Жинхэнэ нарийн өгөгдлүүдийг бодит туршилт шалгалтын үндсэн дээр гаргаж үе үе шалгадаг болно.

Мэдэгдэл

Уг бүтээгдэхүүнийг ашиглахад зориулсан энэхүү мэдээлэл найдвартай мэдээлэл болно. Манай бүтээгдэхүүнийг бидний хяналтгүй нөхцөлд ашиглан хүрсэн үр дүнд компани хариуцлага хүлээхгүй. Манай бүтээгдэхүүн, хэрэглэх арга, танай хэрэгцээнд тохирох эсэхийг өөрсдөө урьдчилсан туршилтаар тогтоох хэрэгтэй. Уг бүтээгдэхүүнийг ашиглахдаа ажиллагсдынхаа аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах нь хэрэглэгчдийн хариуцах зүйл байх ёстой. **Loctite Corporation** энд дурьдсан болон мөрдөгдөж байгаа (үүний дотор манай бүтээгдэхүүнийг арилжах, хэрэглэх, тухайн зорилгод нийцсэн эсэхтэй холбоотой) баталгаанууддыг хариуцахгүй болно. Түүнээс гадна санамсаргүй тохиолдлоор үүссэн ямар нэг эвдрэл гэмтэл, хохирол үүний дотор алдсан ашигийг хариуцахгүй болно. ,Энд дурьдсан төрөл бүрийн процесс, тэр процессын бүрэлдэхүүн хэсгүүдэд тус компанийн болон бусдын эзэмшдэг патент, лицензийн эрх давамгайлахгүй гэж ойлгож болохгүй. Тиймээс хэрэглэгч бүр тэдгээр процессыг давтах талаар өргөдөл гаргахаасаа өмнө тэдгээр эзэмшигчдийн мэдээллийн санг шалгаж мөрдөж байхыг зөвлөж байна. Зарим бүтээгдэхүүн АНУ болон гадаад орны нэг буюу хэд хэдэн патентаар хамгаалагдсан эсвэл патентын өргөдөлтэй байж болно